



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/544

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Өвөрхангай аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээний 3.1.9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний заалны засварын зардалд 7,000,000 (долоон сая), Шүүхийн шинжилгээний албаны байрны засварын зардалд 5,160,000 (таван сая нэг зуун жаран мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дээрх зардал нийт 12,160,000 (арван хоёр сая нэг зуун жаран мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101237